

<https://doi.org/10.69561/mjac.v25i49.3838>

Article | Fasc.13

Үзэмчиний “Ариун тэнгэр” уртын дууны тухай (Төр, найрын хүндэтгэлийн дуу)

Алтан-Уулын Тогтох 

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
✉ atogtohtogtoh@gmail.com

Хураангуй: Монгол туургатны доторх олон янзын өнгө төрхийг бүрдүүлж, монгол хэл, соёлын үнэт нандин өвийг дотроо тээсэн тодорхой угсаатнуудын уртын дууг судалгааны түвшинд төдийлөн нээн гаргаж ирээгүй байна. Монголчууд өнөөдөр дэлхий нийтийн техник технологийн хурдтай хөгжилтэй хөл нийлж, даяаршлын эрин зуунтай нэгдэж амьдрах нь зүй ёсны хэрэг болж байна. Гэвч нийгэм даяаршихын хэрээр уламжлалт соёл, ёс заншил, түүний дотор тодорхой угсаатны соёлын үнэт өв мартагдан алдагдах эрсдэл улам бүр тулгарсаар байна. Үзэмчингүүд олон зуун жилийн өмнөөс зохион дуулж өвлөн уламжилж ирсэн төрийн, найрын, шашны дуунуудыг хуучин дэг жаягаар дуулдаг, үгийг нь мэддэг хүнгүй болж, соёлын үнэт өв мартагдан уламжлал нь үгүй болох, алдагдах, өөр угсаатны дуунд уусах зэрэг эрсдэл улам бүр тулгарсаар байна. Тиймээс бид энэхүү сэдвийн хүрээнд үзэмчин төр, найрын, хүндэтгэлийн “Ариун тэнгэр” уртын дууны аялгуу, шүлэг, яруу найргийн утга бэлгэдэл, хэв намбыг судлан, өвлөн уламжлагчдаас тэмдэглэн ноотлон буулгаж, анх судалгааны эргэлтэд оруулсан болно.

Түлхүүр үгс: *угсаатан, зан заншил, өвлөн уламжлагч, аялгуу, шүлэг яруу найраг*

About a long -song “Ariuntenger” (sacred heaven) of the Uzimchin ethnic group (A respect state and ceremonial song)

Taogete Altan-Uul 

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
✉ atogtohtogtoh@gmail.com

Abstract: A long-song of the proper ethnic groups which bears a valuable cultural heritage of the Mongolian language and culture, forming the different colors of the Mongolian nationalities is not still revealed on the research level.

It is right that the Mongols today live in the globalization era, getting in step with the rapid world technological development. But there is a risk to forget and lose the traditional culture and custom, including a unique cultural heritage of a proper ethnic group. The uzimchins face the risk to forget and lose the traditional culture, no people who sing the state, ceremonial, and religious songs, passed down during many centuries, in their traditional way and know their verse.

So we included the respect state and ceremonial long-song “Ariun Tenger” of the uzimchins in the scientific circulation on the basis of the study of the symbol of its melody and verse, recording and noting it from its bearers. It is distinction that the song is first included in the study circulation.

Keywords: *ethnic group, custom, bearer, melody, verse*

Оршил


Монгол “**төрийн дуу**”-ны дэг ёс нь нарийн чанд ба өөрийн гэсэн үүрэг зориулалттай байдаг. Төрийн ёслол хүндэтгэлийн цэнгүүнд “**төрийн дуу**” нь онцгой үүрэг зориулалтыг өөртөө агуулж байдаг. Түүний нэг нь төрийн дууны дуулах ёсны дэг юм. Дууны дэг ёсонд хувцас дутуу өмсөхгүй, дээлийн энгэр заамыг задгай орхихгүй, үг, шүлгийг буруу дутуу дуулахгүй, амаа том ангайн чанга хашхирч дуулдаггүй төв эрхэмсэг, намбаар дуулдаг байна. “**Төрийн дуу**”-ны үүрэг зориулалт нь “**Найрыг дэглэх**” найрыг эмх цэгцтэй, учир утгатай болгодгоороо онцлогтой. Төрийн найр цэнгээний чухал бүрэлдэхүүн хэсэг нь “**Дуу хуур**” байдаг. Ялангуяа төр найрын цэнгээнд “**Төрийн дуу**” онц чухал үүрэгтэй гүн хүндэтгэл эрхэмсэг ёсны дуу байжээ. Тусгай дэг ёстой дуулагддагаар барахгүй өөртөө ч найр дэглэх үүрэг зориулалтыг шингээж өгсөн байдаг (Эрдэнэчимэг 2013, 64) хэмээсэн.

Монгол уртын дуу нь нэн эртний уг гарвалтай учраас азийн өргөн уудам нутагт тархсан монгол угсаатны бүлэг бүрд олон төрөл зүйлээр хадгалагдан уламжлагджээ. Уртын дуу монголчуудын өдөр тутмын аж ахуй амьдралаас өгсүүлээд төрт ёс, шашин шүтлэг, зан үйл хүртэл асар олон цар хүрээнд хэрэглэгдсээр иржээ. Монголчуудын уртын дуу нь

- Төрийн дуу;
- Айзам дуу (айзан, айдам, айдон, бэхэлгээн дуу);
- Шаштир дуу (үйзэн);
- Гүр дуу;
- Цоор дуу;
- Цээрийн дуу (бэсрэг, шавшаа, гэгэлгэн) гэсэн ерөнхий төрлүүдэд хуваагдан хөгжиж, өнөө үед уламжлагдсаныг монгол туургатны хэмжээнд бодитоор харж болно (Дорждагва 2019, 24) хэмээн ангилан бичсэн байдаг.

Бид энэхүү өгүүлэлдээ юуны өмнө яагаад “**Төрийн дуу**” гэж нэрлэсэн талаарх асуудлыг тодруулах учиртай. Үзэмчин угсаатан аливаа найр наадмыг ямар дуугаар эхлүүлэх, хөгжөөх, өндөрлүүлэх нь амаар журамлагдан, дэг болж мөрдөж ирсэн ард түмэн билээ. Судлаач Н.Бөххад “Үзэмчин монголчуудын найр наадам нь ардын ба ван, гүн язгууртан, гэгээн хувилгаадын наадам цэнгэл гэх хоёр хэлбэрээр өрнөн хэвшиж ирсэн юм. Үзэмчингүүдийн найр наадам нь сүлдний тахилга, овоо

булгийн тахилга, галын тахилга, даллага даллах, цагаан сар, ураг барилдах хурим, ноёд ихсийн зэрэг жинс дэвших буюу залгамжлах, гэгээн хувилгаадын хадаг татах заллага, ноёд түшмэд буюу богд хутагтад тусгай зориулалттай хийсэн найр наадмаас гадна шинэ гэрийн цай, хүүхдийн даахь авах, насны ой, шинийн цай уулзах гэх мэт олон төрөл байдаг ч тэр бүхий найр наадам цөм тогтмол заншил ёсоор төрийн дуу дуулан найрладаг байв (Бөххад 2006, 21) гэжээ. Эндээс төрийн болон жирийн иргэний гэсэн найр наадмын зааг ялгаа харагдаж байна. Бид дээрхээс үндэслэн дараах ангиллыг хийж төрийн найрын дууны хамаарлыг авч үзлээ.



Зураг 1. Төрийн найрын дууны хамаарал

Үзэмчиний төрийн дуу 3, 5, 9, 12 гэж байсан тухай судлаачдын санал харилцан адилгүй байна. Зориулалт, ёс журмын нарийн дэгтэй байжээ. Тухайлбал,

1. Хөдөө сүлдний тахилга (баруун хошуу): “Богд Чингис”, “Их Богд булган хангай”, “Ялгуусан эрхт”
2. Төрийн дуу (зүүн үзэмчин): “Эртийн цагаан буян”, “Ариун тэнгэр”, “Эрдэнийн галбирваас мод”, “Өнгийн гэрэл”, “Богд Чингис” дуу юм.

Тухайн угсаатны бүлгийн төр, түмэн олноо хүндэлж байгаа хүндлэл, төрөө дээдлэн магтаж байгаа зэрэг уг дууны үгнээс илэрдэг. Мөн дууг дуулж байгаа дуучны хэм, өнгө донж нь илрэл болж өгдөг онцлогтой. Тухайн дууг урлан бүтээж амилуулахын үндсийн үндэс нь дуулаачийн дуу хоолой, цараа толио, ур хийц мөн (Ринчэнсамбуу 2011, 168) гэж эрдэмтэн Г.Ринчэнсамбуу тодорхойлсонтой санал нэг байна. Учир нь төрийн дууг бие хаа тэгш, дориун, цог золбоотой, үг урын цэцгэй, ажил хөдөлмөр нь өрнүүн төгс төгөлдрийн цогц хүн дуулна. Энэ нь утга бэлэгдлийн гүн агуулгыг илэрхийлж байгаа юм.

Н.Жанцанноров “Монголчуудын тэнгэрлэг сэтгэлгээ нь уртын дууны аялгууны амин сүнсэнд оршино” (Жанцанноров 1999, 212) хэмээн тодорхойлсон. Мөн монгол уртын дууг урт аялгуутай, уянга дуулалтай, уран чимэглэлтэй, сүрлэг бадрангуй болгож байгаа хүчин зүйл нь үеийн аялгуулал юм (Энэбиш 2017, 67) гэж эрдэмтэн Ж.Энэбиш үзжээ.

Бид энэхүү сэдвийн хүрээнд хил дамнан оршиж буй үзэмчин монголчуудын уртын дуунд эзлэх байр суурь, уламжлагдан ирсэн байдлыг тодорхойлж, түүний

өвөрмөц онцлог хөг аялгуу, яруу найргийн утга бэлгэдийг судлан урын санд хадгалах, судалгааны эргэлтэд оруулах зорилго тавилаа.

Судалгааны арга зүй

Ярилцлагын аргыг ашиглан тухайн уртын дуунд анализ хийж, утга учир бэлгэдийг гаргаж ирсэн. Хээрийн шинжилгээний арга зүй, зураглал бэлдэх арга зүй, дүрс бичлэгийн аппарат зэргийг ашиглан тэмдэглэж авах ажиглалтын арга, судлагдахууны төлөөлөгчийг цуглуулан тандан судлах туршилтын аргыг ашиглав.

Судалгааны үр дүн

Миний бие 2022 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Зүүн Үзэмчин хошууны Улгай суманд хээрийн судалгаагаар ажиллаж “Ариун тэнгэр” уртын дууг өвлөн уламжлагч С.Бүрэнтөгсийн дуулснаар дүрстэй бичлэг хийж судалгааны эргэлтэд оруулсан юм. Үүнийг докторант Ц.Туяацэцэг эгшиглээст буулгаснаар дор үзүүлэв.

“Ариун тэнгэр” уртын дуу

Зураг 2. “Ариун тэнгэр” уртын дуу¹

4 А - рiu - н тэн - гэ - хэ - рийн ээ хн ээ,
7 хю яз - гуур - тай ний,
10 ээ хю А - хуй дэл - гэр сэ - хэ - н бу - ян - тай хи ээ хнэ,
13 Ал - тан - хан хүрд - нээ хэ хэ хн ээ,
15 хн ээ ай хай хи,
19 э - рий - гэ - сэн аа ха ха хи ээ хнэ хи А - мага - лан оо,
22 то - рий - хи хи ээн аа ха,
24 ха хэ хи э - эхд ми - нээ хо.

¹ Үзэмчин уртын дууны өвлөн уламжлагч С.Бүрэнтөгсийн дуулснаар А.Тогтох 2022 онд хээрийн судалгаа хийж дүрстэй бичлэг хийв. Эгшиглээст буулгасан Ц.Туяацэцэг

Аялгууны цараа хоёр наймц давсан гуравц (а-с³) байгаа нь дуучны хоолойн энгийн цараа ойролцоогоор хоёр наймц байдагтай харьцуулахад маш өргөн цараа юм.

Аялгууны эгшиглээ солигдоогүй бөгөөд до эгшиг суурьтай с, d, e, g, а эгшигийн эгнээтэй таван эгшигт юм. Энэ эгшиглэгээг хөгжим судлаачид Монгол таван эгшигтийн III төрөл гэж үздэг бөгөөд суурь эгшгээс их хөгийн гурвал эгшиг байгуулагдах боломжтой байдгаас өрнийн долоон эгшигтийн их хөгийн хандлагатай төрөл гэж үздэг байна.



Зураг 3. “Ариун тэнгэр” уртын дууны эгшигийн цуваа

Царааны нийт өргөнийг гурван чалхад /регистр/ зургаацаар хувааж болно. Аялгууны эхний “а” фраз доод чалханд эхлээд дунд чалх хүрч уруудсан хөдөлгөөнөөр доод чалханд үргэлжлэн аялгууны нэгэн давалгаан үүсгэж байгаа нь дууны оршлын үүрэгтэй байна. Харин хоёр дахь фраз “b” дунд чалханд аялгууг үргэлжлүүлснээр хөгжүүлгийн эрчмийг өргөж өгнө. Гурав дахь фраз “с” энэ хөдөлгөөнийг үргэлжлүүлэн өгссөөр дээд чалханд хүрч дууссанаар аялгууны эрчим улам нэмэгдэж байна. Харин нэг дэх хэсгийн төгсгөл болсон “d” фраз энэ хүчдэлийн өргөлтийг тогтворжуулан доош чиглэлтэй хөдөлгөөн хийж дунд чалханд төгсчээ. Нэгдүгээр хэсгийн аялгууны ерөнхий зураглал аажмаар өгссөөр гурав дахь фразад тухайн хэсгийн дээд оргилд хүрээд тогтворжсон нэг давалгааны хөдөлгөөн үүсгэж байна. Хэлбэр бүтэц аялгууны хөгжүүлгийн хувьд энэ хэсэг бие даасан мөчлөг болж болох боловч зохирлын хувьд тухайлбал, төгсгөл эгшиглээний суурь эгшиг болох “до” эгшигт бус “соль” эгшигт дууссан тул аялгуу цааш үргэлжлэх сэдлийг төрүүлнэ. Хоёрдугаар өгүүлбэрийн эхний фраз аялгууны оргил хэсэг болж байна. Энэ оргил эгшигийн байршил үеийн нийт уртаашын 3/4 -т болно. Аялгууны хөгжүүлгийн ийм байршил хамгийн түгээмэл бөгөөд аялгууны хүчдэл эргээд тогтворжих хугацаа дараагийн хэсгүүдэд үлддэг тул үүнийг “алтан байршил” гэж үздэг байна. Дунд чалханд эхэлсэн аялгуу дээд оргил эгшигт холын үсрэлтгүй аажмаар хүрсэн нь хурц эрэмгий бус, аядуу зөөлөн хэв шинжийг илэрхийлнэ. Мөн оргил эгшигт удаан барилгүй шууд зургаацаар доош үсрэх хөдөлгөөнөөр үргэлжлэх нь дээрх хэв шинжийг бататгана. Хоёр дахь өгүүлбэрийн хоёр дахь фраз болох “f” дунд чалхнаас эхлээд дээд чалханд хүрч дууссан нь өмнөх фразын хүчдэл аажмаар тогтворжих үйлдэл болж байна. “g” фразын аялгуу уруудаад өгссөн хөдөлгөөнтэй байгаа нь оргилд хүрсэн аялгууны хүчдэл аажим аажмаар багасах боловч бүрэн дуусаагүйг илэрхийлнэ. Харин сүүлийн фраз “h” аялгууны доод оргилоос эхлэж байгаа нь аялгууг дуусгах хэсэг ирж байгааг илрүүлнэ. Энэ фраз доод чалханд дууссан ч төгсгөл болох сүүлийн фраз “i” дундаас дээд чалханд хүрээд долооцоор огцом уруудан дунд чалханд дуусаж байна. Энэ хөдөлгөөнийг бид уриалан дуудсан өргөлтийн хэв шинжтэй хөдөлгөөн гэж дүгнэж болно.

Аялгууны ерөнхий зураглал дахь хүчдэлийн хөгжүүлэг ерөнхий нэг давалгаан үүсгэсэн түгээмэл хэв шинжтэй боловч зургаац, долооцын холын үсрэлтүүд, мөн наймц давсан гуравцын үсрэлт “Ариун тэнгэр” дууны давтагдашгүй гоо сайхныг мэдрүүлэх нэгэн хэв шинж болжээ. Ноот бичлэгт зарим чимэглэнг тодорхой тэмдэглээгүй боловч дуучин, уран бүтээлчдийн өв соёлоо өвлөн уламжлах чадварын үр дүнд тус дуу бидэнд дамжин ирсэн.

Шүлгийн утга зүйн судалгаа: Энд бид үзэмчний “Ариун тэнгэр” хэмээх дуунд задлал хийлээ.

Ариун тэнгэр

Ариун тэнгэр нарын ижгууртай (язгууртай)
Ахуй дэлгэрсэн буянтай
Алтан хүрднийг эрхшээсэн
Амгалантай төрийн эжэд (эзэд) минь
 Чинис (Чингис) Богдын ижгуур (язгуур)
 Чин бат төртэй
 Чандмань эрдэнийн чанартай
 Чэнгэлт (цэнгэлт) шулуун ноёд минь
Төрийн долоон эрдэнэс
Төгс чогчлон (цогцлон) бүрдсэн
Түмний дээд ноёнттойгоо
Төвлүүн суугаад найрлая аа
 Үйлс тусыг ариутгасан
 Үнэн батын тахилгыг
 Үндсэн хөгжлийн манлай
 Үжэсгэлэнт (үзэсгэлэнт) хатад эрдэнэтэй
Жасгийн (Засгийн) түшмэдээр
Жасруулах (Засруулах) төрөө бүтээсэн
Жуун (Зуун) овгийг тогтоосон
Жаяадын (Заяадын) тэнгэр ноёд минь
 Хажаар (хазаар) үгүй ажнай
 Халуун гэрэлтийн хүлгийг
 Хамтын тусад хэрэглэсэн
 Хаан төрийн ноёд минь
Балмад дайсны дарлагад
Баатар эрдэнийг дайчлаад
Бат төрийг бүтээгч
Бадрангуй шулуун ноёд минь
 Эрхэм төрийн бүтээлдээ
 Эрдэмт жааныг жохиосон (зааныг зохиосон)
 Энх амгалан төгссөн
 Эеэр жассан (зассан) ноёд минь гэсэн үгтэй.

(Бөххад, Мажиг 2005,72)

“Нэгэн цагт дэлхийн дөрвөн тив (хязгаар)-ийг эрхшээлдээ оруулсан номд үнэнч алтан хүрдэт Загарбардан (санскрит чакравартин; хүрдийг эргүүлэгч) хэмээх нэгэн хаан улс орондоо тогтвортой байдлыг бий болгон, амар хялбар улс иргэнээ удирдан захирахын тулд долоон эрдэнэсийг эзэгнэдэг байсан гэж домоглодог. Эдгээр нь:

1. Тасралтгүй эргэх хүрд эрдэнэ
2. Гэрэл гэгээ цацруулагч, халах халуунгүй, даарах хүйтэнгүй байлгаж, өвчин зовлонгоос сэргийлэн, хүслийг биелүүлэгч чандмань эрдэнэ
3. Бүхнийг эхийн хайраар энэрэгч хатан эрдэнэ
4. Хүч чадал ихтэй, ертөнцийг саадгүй тойрогч, харьтныг дарагч заан
5. Хаан төрд үнэнч, зүтгэлтэй, номын дагуу үйлсийг бүтээгч түшмэл эрдэнэ
6. Шударга, энэрэлтэй, баялаг сангийн эзэн жанжин эрдэнэ
7. Цагаан өнгөтэй, салхи мэт хурдан, эзнээ хамгаалж хүссэн газарт нь хүргэдэг морин эрдэнэ энэ долоо юм гэж үзэж байна.

Загарбардан хаан мянга гаруй хөвгүүдтэй тул хүчирхэг оршин амьдарч, газрын дайдад хүртэлх газар нутгийг хүчирхийллээр биш, зэвсгээр биш, номоор эзлэн амар амгалан амьдарч байсан гэдэг. Олон мянган жилийн дараа хаан нэгэн зарцаа дуудан: “...Зарц аа, хэрэв та гайхамшигт хүрд найгаж, байрнаасаа хөдөлж байгааг харвал надад мэдэгдээрэй” гэж. Мөн олон мянган жилийн дараа гайхамшигт хүрд найгаж, байрнаасаа хөдлөв. Үүнийг зарц нь мэдээд хаанд хэлсэнд хаан “За би хүний баяр баясгалангаар өөрийгөө тайтгаруулж, тэнгэрийн жаргалыг эрэлхийлэх цаг болжээ. Тиймээс эрхэм ханхүү та далай хүртэлх энэ нутгийг хамгаалаарай. Би толгойн үс, эрүүний сахлаа хусаж, шар дээл (хамгийн бэлгэ тэмдэг) өмсөж, гэр оронгүй тэнүүчлэн амьдрах болно” гэжээ. Ийнхүү хаан гэгээнтнийг даяанд орсны долоо дахь өдөр гайхамшигт хүрд эрдэнэс алга болов. Албат нар нь Мэргэн хүнд хэлжээ. Мэргэн хүн хаанд хэлэв. Хаан “Та бүхэн номыг таньж, номыг хүндэлж, номыг дээдэлж, номыг өргөмжлөн, номыг хүндэтгэж, номын туг, номын эзэн болгоорой” (Гердер 1998, 371) гэж хэлж эрдэм номыг дээдлэх тухай сургасан байдаг. Тэгвэл энэ бүх 7 эрдэнийг үзэмчний “Ариун тэнгэр” дуунд дурджээ.

Хүснэгт 1. Үзэмчин дууны утгын задлалын жишээ

Бадаг	Шүлгийн бадаг	Эрдэнийн нэр
Нэгдүгээр бадаг	Ариун тэнгэр нарын язгууртай Ахуй дэлгэрсэн буянтай Алтан хүрднийг эрхшээсэн Амгалант төрийн эзэд минь ээ	Хүрд эрдэнэ
Хоёрдугаар бадаг	Чингис богдын язгуур Чин бат төртэй Чандмань эрдэнийн чанартай Чингэлт шулуун ноёд минь ээ	Чандмань эрдэнэ
Гуравдугаар бадаг	Төрийн долоон эрдэнэс Төгс цогцлон бүрдсэн Түмний дээд ноёдтойгоо Төвлөн суугаад найрлая	Долоон эрдэнэ /Заан эрдэнэ гэж дурдсангүй/

Дөрөвдүгээр бадаг	Үйлс тусыг ариутгасан Үнэн батын тахилгыг Үндсэн хөгжлийн манлай Үзэсгэлэнт хатад эрдэнэтэй	Хатан эрдэнэ
Тавдугаар бадаг	Засгийн түшмэдээр Засруулах төрөө бүтээсэн Зуун овгийг тогтоосон Заяадын тэнгэр ноёд минь ээ	Түшмэл эрдэнэ
Зургаадугаар бадаг	Хазаар үгүй ажнай Халуун гэрэлтийн хүлгийг Хамтын тусад хэрэглэсэн Хаан төрийн ноёд минь ээ	Морин эрдэнэ
Долоодугаар бадаг	Балмад дайсны дарлагад Баатар эрдэнийг дайчлаад Бат төрийг бүтээгч Бадрангуй төрийн ноёд минь ээ	Баатар эрдэнэ

Гуравдугаар бадагт заан эрдэнийг дурдсангүй нь хоёр учир шалтгаантай байж болох юм. Нэгд, монголчууд зааныг төдийлөн мэдэхгүй бөгөөд 3-ын тоог эрхэмлэх үүднээс дахилт маягтай дуулдаг байсан гэж үзэж байна. Хоёрт, заан эрдэнийг дурдсан бадаг мартагдаж, төгсгөлийн бадгийг энд дэс дарааллын дагуу орсон байж болох юм. Эрх биш дууны төгсгөлт энэ бүхнийг нэгтгэн ерөөл өргөх учиртай.

Хэлэлцүүлэг

Уг дууг орчин үеийн хүүхэд, залууст тэнхмийн аргаар сургаж түгээн дэлгэрүүлэх, цаашдаа судалгааны эргэлтэд өргөн далайцтай оруулах чухал юм.

Монгол уртын дуу нь өөр өөрийн угсаатны өвөрмөц хэв маяг, донж, аялгууг шингээсэн байдаг. Үүний нэгэн адил үзэмчин ардын уртын дуу нь өөрийн өвөрмөц төрхтэй боловч мартагдах нөхцөл байдалд хүрч төрөлх өнгө донж, хэв маягаар нь дуулдаг, мэддэг хүмүүс цөөрсөөр байна. Иймээс үзэмчин уртын дууны өв уламжлал, урын сан, өвлөн уламжлагчид, хөг аялгуу, аман яруу найраг зэргийг багцлан судлах, мартагдан дуулагдахгүй болсон уртын дууг өвлөн уламжлагч болон тэмдэглэгдэн үлдсэн баримтаас судлан сурвалжилж, ноотлон тэмдэглэж үлдээх, тэдгээрийн утга агуулга, үнэт чанарыг судалж монгол уртын дууны судалгааны эргэлтэд оруулахыг зорьж төрийн найрын дуу “Ариун тэнгэр” дууг судлан жишээ болгов.

Дүгнэлт

“Ариун тэнгэр” дуунд ноёд хаадыг өргөмжилсөн өнгө аяс байгаа нь төр төлөөлсөн ноёдын найр наадамд дуулагддаг, төрийн дуу байсныг ийнхүү харуулж байна. Төрийн 7 эрдэнийг магтан дуулсан уртын дуу бусад угсаатанд төдийлөн байдаггүй бөгөөд харин шашны, найман тахилын тухай уртын дууг монголчууд өргөн дэлгэр дуулж иржээ. Иймд тус дуу нь яах аргагүй төрийн дуу гэдгийг харуулж байна. Нөгөөтэйгүүр үзэмчин уртын дууны шүлэг, аялгууны уран сайхны онцлогийг цогцоор нь харуулж байна. Тухайлбал, тухайн дууны шүлгийг аваад үзвэл бурхан шашны гэхээсээ илүү төр ёсны үзэл суртлыг иргэний үзэл санаа,

бодол дүгнэлтийн хүрээнд сайтар зохиомжилсон сонгодог жишээ болж байна. “Ариун тэнгэр” дуу хэлбэрийн хувьд хөгжингүй, царааны хувьд өргөн бөгөөд аялгуу хөгжүүлгийн чухал онцлог хэв шинжтэй бөгөөд агуулгын хувьд төр шашны сэдэвтэй дуу тул уртын дууны хамгийн том төрөл болох айзам уртын дууны бүхий л хэв шинжийг төлөөлж чадах дуу юм гэж үзэж байна. Үүнийг дээр задлан ноотлож, анализ хийснээс харагдаж байна.

Ашигласан материалын жагсаалт

Бөххад, Н., Мажиг, Б. 2005. *Үзэмчин ардын домогт дуу*. ӨМӨЗО.

Бөххад, Н. 2006. *Монгол уртын дууны өлгий үзэмчин*. ӨМӨЗО.

Гердер, И.Г. 1998. “Овлиянии поэзии на нравы народов в старые и новые времена / пер. с нем. А.В. Михайлова.” *Хрестоматия по культурологии*. Ред. А.А. Радугина. Москва.

Дорждагва, Н. 2019. *Өвөр монголчуудын уртын дууны өв*. Улаанбаатар.

Жанцанноров, Н. 1999. “Монгол ардын уртын дууны 3 сэдэл.” *Монголын соёл, урлаг судлал*: I-II.

Чулуунбаатар, Г., Мөнхцэцэг, Б. 2017. *Шинжлэх ухааны танин мэдэхүйн логик, судалгааны ажлын арга зүй*. Улаанбаатар: Мөрөөдлийн гурвалжин ХХК.

Энэбиш, Ж. 2017. *Монгол хөгжмийн их нүүдэл. Боть IV*. Улаанбаатар: “Адмон принт” ХХК.

Эрдэнэчимэг Л. 2013. *Гүр дууны гүн эгшиглэн*. Улаанбаатар.

Ярилцлага:

Тогтох, А. “БНХАУ-ын ӨМӨЗО-ны Зүүн Үзэмчин хошууны Улгай суманд хийсэн хээрийн судалгааны бичлэг.” 2022. 3:15:00.